



# МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ  
ТӨХК-ИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/53/СТА-ТӨҮГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

2018 он



**YAAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

YAAG-ын САГ-ын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663  
Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: Я.Самбууням  
Утас: 261885  
Цахим хаяг: [sambuunyamya@audit.gov.mn](mailto:sambuunyamya@audit.gov.mn)

Аудитор: Н.Нямдаваа  
Утас: 260512  
Цахим хаяг: [nyamdavaa.n@audit.gov.mn](mailto:nyamdavaa.n@audit.gov.mn)

YAAG-ын хаяг: Монгол Улсын Үндэсний аудитын газар  
Засгийн газрын IV байр, Бага тойруу-6,  
Улаанбаатар-46, Монгол улс  
Веб сайт: [www.audit.mn](http://www.audit.mn)



“МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК

Гүйцэтгэх захирал: С.Мөнхбаяр  
Утас: 88106070  
Цахим хаяг: [info@magicgroup.mn](mailto:info@magicgroup.mn)  
Аудитын менежер: Г.Мөнхбаяр  
Утас: 88112064  
Цахим хаяг: [s.oyunaa@magicgroup.mn](mailto:s.oyunaa@magicgroup.mn)

Аудитор: Б.Ананд  
Утас: 99919187  
Цахим хаяг: [audit@magicgroup.mn](mailto:audit@magicgroup.mn)  
Хаяг:

УБ хот Баянгол дүүрэг Калорода төв  
101 тоот

2018 оны 3 дугаар сар 12

## “ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН

2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН


## Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан



<b>АГУУЛГА</b>	
1	Аудитын гэрчилгээ ..... 0
2	Аудитын тайлан ..... 1
2.1	Оршил ..... 1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... 3
2.5	Дотоод хяналт ..... 4
2.6	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... 4
2.7	Шилэн дансны мэдээлэл ..... 7
2.8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар ..... 8
2.9	Гол онцлох гүйлгээний талаар ..... 8
2.10	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар..... 9
2.11	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл ..... 9
2.11.1	Мөнгөн хөрөнгийн талаар..... 9
2.11.2	Үндсэн хөрөнгийн талаар ..... 9
2.11.3	Даатгалын зардлын талаар..... 9
2.11.4	Тендер бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын талаар ..... 10
2.11.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар ..... 10
2.11.6	Орхон аймаг дахь салбарт хийсэн аудитын талаар..... 10
2.12	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд ..... 11
2.13	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл ..... 11
2.14	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 12
2.15	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: ..... 12
2.16	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... 12
3	Менежментийн захидал..... 13
3.1	Мөнгөн хөрөнгийн талаар..... 14
3.2	Үндсэн хөрөнгийн талаар ..... 15
3.3	Даатгалын зардлын талаар..... 16
3.4	Эзний өмчийн талаар ..... 17
3.5	Татварын талаар..... 18
3.6	Тендер, худалдан авалтын талаар ..... 19
3.7	НББ-ийн бодлогын баримт бичгийн талаар..... 20
3.8	Орхон аймаг дахь салбарын талаар..... 21
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшин ..... 23
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан..... 23
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан..... 24
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан..... 25
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан..... 26
4.5	ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 27





## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ  
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Б.НЯМСАМБУУ ТАНАА

2018.03.15 № 06/710  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударгаар илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_KhereglYawsan\_Bichig\2018\0315SAG40.Docx

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

071386

## Үүрэг, хариуцлага

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig\_Khureg\Yawsan\_Bichig\2018\0315\SAAG40.Docx



## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 Оршил

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн аудитын тайланг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц.Баяр-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшингийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалт, орлого, зардал, авлага, өглөг, эзний өмч, тендер бараа үйлчилгээний худалдан авалт, татвар зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Гүйцэтгэх удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2017 оны тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 07-ноос 2018 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн Мэжик консалтинг аудит ХХК-ийн Ерөнхий захирал С.Мөнхбаяр, ахлах аудитор Г. Мөнхбаяр, аудиторын туслах Б.Ананд, Х.Амгаланзаяа, Б.Алтантуяа нар хэрэгжүүлж ажиллав.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 01/202 дугаартай албан бичгээр Мэжик консалтинг аудит ХХК-д ирүүлсэн болно. Аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр байгууллагын удирдлагад гардуулна.

### 2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь “Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи ашиглан цахилгаан эрчим хүчийг үр ашигтай дамжуулна” гэсэн эрхэм зорилготой ажиллаж байна.

Тус компани Улаанбаатар хот болон орон нутагт 5 салбартай, тэдгээр нь Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу үйл ажиллагаа явуулдаг. Салбарууд нь санхүүгийн тайлангаа СТОУС 10 “Нэгтгэсэн санхүүгийн тайлан”-ын дагуу бэлтгэж төв компанийн санхүүгийн тайланд нэгтгэдэг байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 08 дугаар тогтоолоор Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг 10,196.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,382,144,358 ширхэг энгийн хувьцаатай гэж нэмэгдүүлж баталсан байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага болох Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь Компанийн Гүйцэтгэх захирлыг томилж гэрээ байгуулсан байна. Гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.1-д “хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх”, 84.4.2-т “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх”, 84.4.3-т “компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах” гэж заасны дагуу компанийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааг удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцан ажиллаж байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь Эрчим хүчний тухай, Компанийн тухай, Иргэний тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Шилэн дансны тухай, Нийгмийн даатгалын багц хууль, Татварын багц хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Архивын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиуд, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, Монгол Улсын Засгийн газар, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо бусад яам агентлагаас гаргасан тогтоол, тушаал, дүрэм, журам, заавар, аргачлал, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт

/СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна. Харин Эрчим хүчний зохицуулах хорооноос (ЭХЗХ) тус компанийн цахилгаан эрчим хүчний дамжуулалтын үйлчилгээний төлбөр буюу тарифыг 3 удаа нэмж баталсан. Үүнд:

1. ЭХЗХ-ны 2017 оны 30 дугаар тогтоолоор 01-07 дугаар сар, 09-11 дүгээр сард 3,255.5 сая төгрөгөөр,
2. ЭХЗХ-ны 2017 оны 205 дугаар тогтоолоор зөвхөн 8 дугаар сард өмнөх тарифыг 234.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн сард 3,490.0 сая төгрөгөөр,
3. ЭХЗХ-ны 2017 оны 383 дугаар тогтоолоор 12 дугаар сард өмнөх тарифаас 1,083.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 4,339.4 сая төгрөгөөр тарифыг тогтоосон байна.

Дамжуулалтын үйлчилгээний төлбөр буюу тарифыг нэмсэн гол шалтгаан нь дараах зардлуудыг нэмэгдсэнтэй холбоотой байна. Үүнд:

- Хөшигтийн хөндийн үндсэн цахилгаан хангамжийг 110/35/10 кВ-ын Найрамдал дэд станцаас хангахад шаардлагатай материалын зардал 73,7 сая төгрөгийн эх үүсвэрт.
- 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцыг сэргээн засварлахад шаардлагатай зардал 160,9 сая төгрөгийн эх үүсвэрт.
- Компанийн нийт ажилтнуудын үндсэн цалинг ТУЗ-ийн 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор 07 дугаар сарын 01-ний өдрөөс 10 хувиар нэмэгдүүлсэн.

#### 2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэх удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 26 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 1 хувиар тооцож 1,595.0 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Ординат” ХХК-ийн боловсруулсан “Юникус” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу бэлтгэж гаргасан байна.





## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамтай байна” гэж заасантай нийцүүлэн Гүйцэтгэх захирлын 2013 оны А/69 дүгээр тушаалаар Дотоод аудитын хяналт шалгалтын журам”, 2016 оны А/230 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”, 2013 оны А/57 дугаар тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус баталсан байна. Дотоод аудит болон дотоод хяналтын нэгж, өмч хамгаалах байнгын зөвлөл нь тайлант онд хийх ажлын төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний биелэлт, шалгалтын ажлын тайланг компанийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр хугацаатай албан даалгавар өгч, биелэлтийг сар бүр гаргуулан авч ажилласан байна. 2017 онд санхүүгийн дотоод аудитын шалгалт явуулах ажлын хуваарийн дагуу Говийн бүсийн салбар, Зүүн өмнөд бүсийн салбар, Төвийн бүсийн салбар, Хангайн бүсийн салбар, Улаанбаатарын салбар, төв компаниудын санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн байна.

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.2-д заасны дагуу компанийн Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нар өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутамын хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

## 2.6 ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 225 дугаар тогтоолоор компанийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн анхны төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант онд Оюу Толгой ХХК-тай “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах тухай” гэрээний дагуу (...БНХАУ-ын Өвөр Монголын Эрчим хүчний олон улсын хамтын ажиллагааны компанитай байгуулсан “Монгол улсын Оюу Толгой төсөлд зориулж цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах тухай” гэрээ, Оюу Толгой ХХК-тай “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах тухай” гэрээний дагуу үүссэн ажил гүйлгээг Сангийн яамны 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 07/7278 дугаар албан бичигт Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) 15 “Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого”-д нийцүүлэн борлуулалтын орлого болон борлуулсан бүтээгдэхүүний өртгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ...) гэж заасны дагуу компанийн 2017 оны орлого, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт бүртгэж, тайлагнасан байна. Энэ орлого зардал нь компанийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөнд батлагдаагүй байна. Иймд 2017 оны зорилтот түвшингийн төлөвлөгөөний биелэлтээс энэхүү орлого зардлыг хассан дүнгээр тайлбар тодруулга хийлээ.

САГ-2018/53/СТА-ТӨҮГ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 225 дугаар тогтоолоор батлагдсан компанийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр үзүүлэв.

Д/Д	ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	2016 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	2017 ОНЫ		Харьцуулалт				
				ТӨЛӨВЛ ӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭ Л	Төлөвлөгөөтэй		Өмнөх оноос		
						Тоо	Хувь	Тоо	Хувь	
1	Дамжуулах цахилгаан эрчим хүч	сая.кВт.ц	4,884.4	4,920.6	5,171.3	250.7	105.1	286.9	105.9	
2	Дамжуулалтын алдагдал	хувиар	3.3	3.5	3.4	-	0.2	95.7	0.0	101.1
		биетээр	сая.кВт.ц	161.9	172.4	173.4	1.0	100.6	11.5	107.1
3	Дамжуулсан цахилгаан эрчим хүч	сая.кВт.ц	4,722.4	4,748.2	4,997.9	249.7	105.3	275.4	105.8	
4	Нийт орлого	сая.төг	41,080.4	44,448.1	159,505.6	115,057.5	358.9	118,425.3	388.3	
	Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны орлого	сая.төг	38,147.6	43,111.4	40,384.1	-	2,727.3	93.7	2,236.5	105.9
	Оюутолгой ХХК-тай ЦЭХ, худалдан авах, худалдах гэрээний дагуу тооцсон орлого	сая.төг	-	-	113,923.9	113,923.9	-	-	113,923.9	-
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая.төг	2,932.8	1,336.7	5,197.6	3,860.9	388.8	2,264.9	177.2	
5	Нийт зардал	сая.төг	40,983.5	44,448.1	159,433.0	114,984.9	358.7	118,449.5	389.0	
	Үүнээс: Удирдлагын зардал	сая.төг	171.0	206.5	253.2	46.7	122.6	82.2	148.1	
6	Татварын өмнөх ашиг /алдагдал/	сая.төг	96.9	-	0.0	72.7	72.7	-	24.2	75.0
	Орлогын татварын зардал	сая.төг	320.5	-	39.6	39.6	-	-	-	
	Цэвэр ашиг алдагдал	сая.төг	-	223.6	-	0.0	33.1	-	256.7	-
7	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал	төг	1.0	1.0	1.0	-	0.0	100.0	0.0	100.2
8	Нийт авлага	сая.төг	3,306.6	2,291.5	5,497.1	3,205.6	239.9	2,190.5	166.2	
	Үүнээс: Богино хугацаат авлага	сая.төг	1,988.3	1,039.1	4,244.7	3,205.6	408.5	2,256.4	213.5	
9	Нийт өр төлбөр	сая.төг	21,865.9	22,487.2	22,320.6	-	166.6	99.3	454.7	-
	Үүнээс: Богино хугацаат өглөг	сая.төг	2,580.2	2,131.7	3,910.7	1,779.0	183.5	1,330.5	151.6	
10	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт	сая.төг	6,384.0	9,590.0	12,164.3	2,574.3	126.8	5,780.3	190.5	
	Үүнээс: Их засвар	сая.төг	1,785.7	2,079.6	1,772.0	-	307.6	85.2	-	13.7
	ТЗБАХ	сая.төг	3,526.4	5,914.5	8,979.8	3,065.3	151.8	5,453.4	-	
	Хөрөнгө оруулалт	сая.төг	1,071.9	1,595.9	1,412.5	-	183.3	88.5	340.7	131.8
11	Нийт ажилтны тоо	хүн	1,086.0	1,207.0	1,142.0	-	65.0	94.6	56.0	105.2
12	Цалингийн сан	сая.төг	19,751.9	22,512.4	20,925.1	-	1,587.3	92.9	1,173.2	105.9

**Цахилгаан эрчим хүчний дамжуулалт:** Дамжуулах цахилгаан эрчим хүчний 4,920.6 сая кВт.цагийн төлөвлөгөөтэй, 5,171.3 сая кВт.цагийн гүйцэтгэлтэй ажиллаж, цахилгаан эрчим хүчний дамжуулалтын нийт алдагдалд 3,50 хувь буюу 172,4 сая кВт.цаг зарцуулахаас гүйцэтгэлээр 3,35 хувь буюу 173,4 сая кВт.цаг зарцуулсан байна.

Дамжуулсан цахилгаан эрчим хүчний 4,748.2 сая кВт.цагийн төлөвлөгөөтэй, 4,997.9 сая кВт.цагийн гүйцэтгэлтэй ажиллаж, цахилгаан эрчим хүч дамжуулалт өнгөрсөн оны мөн үеэс 5,8 хувиар буюу 275,4 сая кВт.цагаар, төлөвлөгөөнөөс 5,3 хувиар буюу 249,7 сая кВт.цагаар тус тус өссөн байна

**Орлогын гүйцэтгэл:** 2017 оны орлогын төлөвлөгөө нийт **41,080.4** сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр нийт **45,581.7** сая төгрөгийн орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөөг 2,6 хувиар буюу 1,133.6 сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 11,0 хувиар буюу 4,501.3 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна. Үүнээс үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 2,727.3 сая төгрөгөөр тасарсан боловч үндсэн бус үйл ажиллагааны орлого 3,860.9 сая төгрөгөөр өссөн нь орлогын төлөвлөгөө 1,133.6 сая төгрөгөөр нэмэгдэхэд гол нөлөө үзүүлсэн байна.

**Зардлын гүйцэтгэл:** 2017 онд нийт **44,448.1** сая төгрөгийн зардал батлагдаж, **45,509.1** сая төгрөг зарцуулж, төлөвлөгөөт зардлыг 1,060.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн

байна. Зардлын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11.0 хувиар буюу 4,525.5 сая төгрөгөөр, төлөвлөгөөтэй харьцуулахад 2.4 хувиар буюу 1,060.9 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн байна.

Зардлын хэтрэлтийн гол шалтгаан нь *үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал* төлөвлөснөөс 33,4 сая төгрөгөөр, *судалгаа хөгжлийн зардал* 25,6 сая төгрөгөөр, *газрын төлбөр* 19,1 сая төгрөгөөр, *удирдлагын зардал* 46,7 сая төгрөгөөр хэтэрсэнтэй болон 2017 оны бизнес төлөвлөгөөнд дараах нэр төрлийн гэрээт ажлаас олох орлого, түүнд зарцуулах зардал тусгагдаагүйтэй холбоотой орлого нэмэгдэж, нөгөө талдаа зардал хэтэрсэн байна. Үүнд:

- a) “МАК” ХХК-тай байгуулсан 220/110/35 кВт-ын Оюутолгой дэд станцын Цагаан суварга гаргалгааны өргөтгөл, автотрансформатор суурилуулах барилга угсралтын гэрээт ажлын зардал 1,667.4 сая төгрөг,
- b) “ДЦС-4” ХК-тай байгуулсан 2017/58 тоот гэрээт ажлын зардал 652,5 сая төгрөг,
- c) Багахангай дэд станцыг 2017 онд гүйцэтгэгч компани улсын комисст албан ёсоор хүлээлгэж өгөх байсан боловч энэ ажил хийгдээгүй тул гэрээ байгуулан ажилтнуудын цалинд 109,2 сая төгрөгийг зарцуулсан.

БНХАУ-ын Гоухе дэд станцаас, Оюу Толгой ХХК-д дамжуулсан “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах тухай” гэрээнд үндэслэн Оюу Толгой ХХК, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу тооцсон 113,923.9 сая төгрөгийг Сангийн яамны албан бичгийг үндэслэн үндсэн үйл ажиллагааны орлого, зардалд бүртгэж тайлагнасан байна.

Үр дүн цэвэр ашиг: Тайлант онд нийт 44,448.1 сая төгрөгийн орлого олж, 44,448.1 сая төгрөгийн зардал гаргаж алдагдалгүй ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 45,581.7 сая төгрөгийн орлого олж, 45,509.1 сая төгрөгийн зардал гарган 72,7 сая төгрөгийн ашигтай ажиллаж, борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал 1,00 төгрөг гарсан нь төлөвлөсөн хэмжээнд байна.

Богино хугацаат авлага 4,244.7 сая төгрөг болж оны эхнээс 2,256.4 сая төгрөгөөр, батлагдсан төлөвлөгөөнөөс 3,205.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Богино хугацаат авлагын өсөлт нь:

- Тайлант хугацааны эцэст ЭХЗХ-ны мөнгөний урсгалын хувь хэмжээний зохицуулалттай холбоотойгоор Нэг худалдан авагчаас авах цахилгаан эрчим хүчний дамжуулалтын авлага 1,168.1 сая төгрөгөөр өсөж 2,806.7 сая төгрөгт хүрсэн.
- Бусад авлага 1,088.3 сая төгрөгөөр нэмэгдэж 1,402.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бусад авлагын бүрэлдэхүүнд ажилтнуудаас авах байрны төлбөрийн авлага 243,7 сая төгрөг, “МАК” ХХК-иас гэрээт ажлын авлага 276,3 сая төгрөг, “ДЦС-4” ХК-иас гэрээт ажлын авлага 439,2 сая төгрөг, “Масса” ХХК-ийн бараа нийлүүлэлтийн авлага 247,1 сая төгрөг эзэлж байна.

Урт хугацаат авлага 1,252.4 сая төгрөг нь Германы Сэргээн босголт зээлийн банкны “Эрчим хүчний хөтөлбөр-1” төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу “ДЦС-3” ХК, “ДЦС-4” ХК, “Дархан” ДЦС ХК-д суурилагдсан тоног төхөөрөмжүүдийн зээлийн төлбөр юм. (“ДЦС-3” ХК 348,2 сая, “ДЦС-4” ХК 257,5 сая, “Дархан” ДЦС 646,7 сая төгрөг)

Богино хугацаат өр төлбөр 3,910.7 сая төгрөг болж оны ажлын үлдэгдлээс 1,330.5 сая төгрөгөөр, төлөвлөгөөнөөс 1,779.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна.



Богино хугацаат өглөгийн өсөлт нь:

Нийт 1,811.1 сая төгрөгийн гэрээт ажлын урьдчилгаа төлбөрийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн нь богино хугацаат өглөгийн өсөлтөд нөлөөлсөн байна.

Сангийн яамтай байгуулсан дамжуулан зээлдэх гэрээний дагуу 2018 онд төлөх 1,441.7 сая төгрөгийн урт хугацаат зээлийн үндсэн төлбөрийг тайлант хугацаанд богино хугацаат өглөгөөр бүртгэсэн.

Урт хугацаат зээл Монгол улсын Их хурлын 72 дугаар тогтоолын дагуу урт хугацаат зээлийг анх зээлсэн ханшаар тооцон төгрөгт шилжүүлэн дамжуулан зээлдэх гэрээг Сангийн яамтай байгуулсны дагуу дараах төслүүдийн урт хугацаат өглөгийг бүртгэж, 2017 онд 1,429.6 сая төгрөгийг Сангийн яаманд төлж, оны эцэст **17,959.6** сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

Д/д	КОМПАНИД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН НЭР	2017 ОНЫ			2018 ОНД ТӨЛӨХ ДҮН
		эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	Сангийн яаманд төлсөн дүн	
1	АХБанкны зээлээр хэрэгжсэн "Эрчим хүчний хэмнэлт" төсөл	936.1	869.3	66.9	66.9
2	Германы СБЗБанкны зээлээр хэрэгжсэн "Эрчим хүчний хөтөлбөр-1" төсөл (Багц-2)	2,704.4	2,562.0	142.3	142.3
	Германы СБЗБанкны зээлээр хэрэгжсэн "Эрчим хүчний хөтөлбөр-1" төсөл (нэмэлт)	4,175.2	3,955.4	219.7	219.7
3	Шведийн олон улсын хөгжлийн агентлаг /SIDA/-ын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжсэн "Дамжуулах сүлжээний шинэчлэн засварлах төсөл	7,208.9	6,433.1	775.8	450.3
	Шведийн олон улсын хөгжлийн агентлаг /SIDA/-ын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжсэн "Дамжуулах сүлжээний шинэчлэн засварлах төсөл, нэмэлт	2,060.0	1,945.7	114.4	429.0
4	Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "Багануур", "Шивээ-Овоо" хувьцаат компанийн нүүрсний уурхайг шинэчлэх "МОН П-5" төсөл	1,743.4	1,634.4	109.0	109.0
5	"УБДС" ХК-ийн "Дулааны үр ашгийн төсөл"	7.3	5.8	1.5	0.4
6	"УБЦТС" ХК-ийн Дэлхийн банкны эрчим хүчний анхны төсөл болон Нэмэлт санхүүжилтийн төсөл		553.9		24.1
<b>НИЙТ ДҮН</b>		<b>18,835.4</b>	<b>17,959.6</b>	<b>1,429.6</b>	<b>1,441.7</b>

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2017 онд Шилэн дансны тухай хуулийн дагуу төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор гаргасан удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоог хуулийн дагуу хангасан талаарх мэдээллийг шилэн дансны вебсайт хуудсанд байршуулсан мэдээллийг шалгаж үзэхэд орлого, зардал, удирдлагын шийдвэр, тендер шалгаруулалт, худалдан авалт зэрэг онцлох ажил гүйлгээний талаарх мэдээллийг [www.shilendans.gov.mn/org/5228](http://www.shilendans.gov.mn/org/5228) сайтад байршуулж олон нийтэд толилуулж байна.

Вебсайт хуудсанд байршуулсан шилэн дансны мэдээллээс үзэхэд мэдээллийг бүрэн оруулсан ба 2 удаагийн мэдээллийг хугацаа хоцроосон байна. Эрчим хүчний яамны Дотоод аудитын газраас 2017 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд багтах төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хяналт хийж, ЦДҮС ТӨХК-ийг Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 29 дүгээр тогтоолын хавсралт журмын дагуу мэдээллийг 100 хувь байршуулсан, хугацаанд байршуулсан байдалд 95 хувь, нийт 95 хувийн үнэлгээ өгсөн байна.

## 2.8 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Аудитад Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагын олон улсын стандарт (СТОУС) болон холбогдох Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн зүйл заалтыг шалгуур болгон авав.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь Гүйцэтгэх захирлын 2009 оны тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлдээ мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар, мөн 2014 оны тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын дагуу Нягтлан бодох бүртгэлийн горим, дансдын нийтлэг бичилт, жишиг жагсаалт, нэгдсэн кодчилол, Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцох журам” зэрэгт орсон өөрчлөлтийн дагуу шинэчлэгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн төрийн байгууллагаас гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журамтай нийцэхгүй байна.

Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн програм хангамжийн үйл ажиллагааг ярилцлага асуулгын аргаар судлав. Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэхэд хэрэглэж байгаа “Ординат” ХХК-ийн боловсруулсан “Юникус” програм хангамжийн мэдээлэл боловсруулалтын үр дүн нь Монгол улсын хууль, НББОУС-д нийцүүлж боловсруулсан журам, зааварт нийцэж байна. Харин компанид мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн агуулга програмтай нийцэхгүй байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ өгч, аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

## 2.9 Гол онцлох гүйлгээний талаар

Компанийн 2017 оны санхүүгийн тайланд тусгагдсан онцгой үйл явдал, санхүүгийн тайлагналд нөлөөлөхүйц хэмжээний томоохон дүнтэй хийгээд аудиторын анхааралд өртсөн онцлог, том дүнтэй ажил гүйлгээ бүрийг эрэмбэлэн шүүх аргаар судлав. Ийм ажил гүйлгээний хувьд анхан шатны баримтын бүрдэл, хөрөнгө, эх үүсвэрийн дансдад гарсан өөрчлөлт, хөдөлгөөн, аж ахуйн үйл явдал, ажил гүйлгээг тохирох батламж мэдэгдлийн шалгуураар авч үнэлсэн болно.

1. Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар говийн бүсийн салбарт 30,652.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, АПУ ХК-аас 20.0 сая төгрөгийн хандив, нийт 30,672.8 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд хойшлогдсон орлогоор бүртгэж, 2017 онд **1,057.8** сая төгрөгийн элэгдэл байгуулан, элэгдлийн зардал болон бусад орлогоор бүртгэж, тайлагнасан байна.
2. БНХАУ-ын Гоухе дэд станцаас, Оюу Толгой ХХК-д дамжуулсан “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах тухай” гэрээнд үндэслэн Оюу Толгой ХХК, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу тооцсон 113,923.9 сая төгрөгийг Сангийн яамны албан бичгийг үндэслэн үндсэн үйл ажиллагааны орлого, зардалд бүртгэж тайлагнасан байна.

## 2.10 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 42 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 30 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

## 2.11 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, орлого, зардал, авлага, өглөг, үндсэн хөрөнгө, цалин хөлсний тооцоо, эзний өмч, тендер бараа үйлчилгээний худалдан авалт, шилэн данс, татвар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгав. /ТАБ-СТА-В-3/

### 2.11.1 Мөнгөн хөрөнгийн талаар

Тус компанийн кассын тайланд аудит хийж, түүврийн сорил хийж шалгахад 1,5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 120 удаагийн гүйлгээгээр нийт 332,9 сая төгрөгийн зарцуулалт гарсан байна. Энэ нь Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны А/119 дүгээр тушаалаар батлагдсан “Кассын үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.4-ийн Д-д “кассын нэг удаагийн зарлага нь 1.5 сая төгрөгөөс хэтрэхгүй байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЦДҮС ТӨХК-ийн “Кассын үйл ажиллагааны журам”-д нийцүүлэн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх.

### 2.11.2 Үндсэн хөрөнгийн талаар


Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр ТУЗ-ийн 2017 оны 32 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын А/234 дугаар тушаалаар 157.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, 75.6 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 81.6 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий үндсэн хөрөнгийг данснаас хасч бүртгэсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар үндсэн хөрөнгийг зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр данснаас хасах буюу борлуулах, устгах эрхтэй” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх

### 2.11.3 Даатгалын зардлын талаар

Тус компани 2017 оны 9 дүгээр сараас 2018 оны 9 дүгээр сарын хугацаанд хэрэгжих гэнэтийн ослын даатгалд 29.3 сая төгрөг, 2017 оны 5 дугаар сараас 2018 оны 5 дугаар сарын хугацаанд хэрэгжих тээврийн хэрэгслийн даатгалд 12.6 сая төгрөг, жолоочийн хариуцлагын даатгалд 8.2 сая төгрөг, нийт 50.6 сая төгрөгийн даатгалын төлбөрийг тайлант оны зардлаар бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалын 2.1.5-д заасны дагуу “Хууль тогтоомжийн дагуу төлөх татвар, шимтгэл болон байгууллага, хүмүүстэй хийсэн гэрээгээр үйл ажиллагааны зардлыг урьдчилан төлбөл урьдчилж төлсөн зардлаар хүлээн зөвшөөрч, зардал хэрэгжсэн үед урьдчилж төлсөн зардлаар бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

САГ-2018/53/СТА-ТӨҮГ



Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалын 2.1.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх.

#### 2.11.4 Тендер бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын талаар

ЦДҮС ТӨХК-ийн 2017 оны бараа, ажил үйлчилгээний худалдан авалтын 13 бараа, ажил үйлчилгээний тендерийн баримт бичгийг түүвэрлэн хянаж үзэхэд дараах зөрчлүүд илэрч байна. Үүнд:

Дараах 6 тендер шалгаруулалтад 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэл явуулаагүй байна.

- ИХБ-4-ийн РШ-1, 2 болон Өмнөд дэд станцад галын дохиоллын систем суурилуулах
- 110 кв-ын Арвайхээр шугамын анкет тулгуур дагалдах хэрэгслийн хамт нийлүүлэх
- Хот дэд станц ЯЧ16 болон ЯЧ26 гэр хороолол 6 кв-ын вакуум таслуур микропроцессорын реле хамгаалалтын хамт нийлүүлэх
- Техникийн мэдээллийн сан програмын өргөтгөлийн ажил, хуучин сервер компьютеруудыг шинэчлэх
- Компанийн оффисын байрны өрөөнд галын дохиоллын систем нийлүүлэх
- 110/35/10 кв-ын Мандалговь, Даланзадгад дэд станцуудын 35 кв-ын хоёр талдаа газардуулгын хутгатай хуурай салгуур 7 ком, нэг талдаа газардуулгын хутгатай хуурай салгуур 6 ком приводын хамт солих

